

Ц.Бадрах, Эдийн засагч
ҮСГ-ын ХАТСТ-ны ахлах мэргэжилтэн

Монгол улсын хүн амын тоо, өсөлтийн түүхэн хандлага, орчин үед анхаарах зарим асуудал

Энэхүү ажил нь Монгол улсын хүн амын өсөлтийн түүхэн хандлага, түүний үр нөлөөний талаарх судлаачийн дүгнэлт, үзэл бодлыг илэрхийлжээ. Судлаач ажилдаа Монгол улсын хүн амын анхны тооллогоос авахуулаад хамгийн сүүлийн тооллого хүртэлх бүх тооллогын мэдээллүүдэд үндэслэн хүн амын тоо, өсөлтийн өөрчлөлт, тэдгээрийн онцлог, шалтгааныг улс төр, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн нөхцөл байдалтай уялдуулан дэлгэрэнгүй тайлбарласан бөгөөд олон олон сонирхолтой түүхийн баримтуудыг ашигласан байна. Түүнчлэн дээрх сэдэвтэй холбоотой төрөөс хүн амын талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, ололт, сургамжийн талаар өөрийн санал, дүгнэлтүүдийг гарган тавьсан нь ихээхэн сонирхол татахуйц байна. Уншигч та энэхүү судалгааны дэлгэрэнгүй үр дүнг доорх бүтээлээс уншина уу.

а.Хүн амын өсөлтийн түүхэн хандлага

Монголын хүн амын тоо урт удаан хугацаанд тодорхой биш, Монголын түүхийг судалсан эрдэм шинжилгээний зарим бүтээлүүд дэх хүн амын тооны талаарх баримт нь хоорондоо маш их зөрүүтэй байсан тухай эрдэмтдийн тэмдэглэл байдаг.

Монголын хүн амын тооны олон янз байсныг нэг мөр цэгцтэй тоо болгож гаргах анхны зорилтыг Оросын эрдэмтэн, эрдэм шинжилгээний ангийн ахлагч, И.М. Маяский дэвшүүлж, 1918 онд Монголд анх удаа хүн амын тооллого явуулжээ. И.М. Маяский номондоо “Гадаадад Монголын хүн амын тоо урт удаан хугацаанд оньсого байлаа гээд цааш нь манай шинжилгээний анги энэ оньсогыг бүрэн тайлж чадахгүй ч ямарч болов гадаад Монголын газар нутаг дахь хүн амын тоог тодорхойлохыг зорив. Гэхдээ энэ хүн амын тооллого бүрэн биш нь үнэн юм. Тэр нь зөвхөн Монголчуудад хамааралтай бус, мөн 1918 онд гадаад Монголд амьдарч байсан хятад, оросуудад хамаарна. Цааш нь Ховдын хязгаар, Хөвсгөл нуур орчмын Богд гэгээний нутаг дэвсгэрийн хүн амын тоо ороогүй, шинэ төрлийн татвараас зайлсхийж ам бүл, малын тоогоо нууж байсан нь тооллогын дүнг алдаатай гарахад нөлөөлж байв” гэжээ (28 дугаар нүүр, И.М.Маяский, Монголия накануне революций, издательство восточной литературы, Москва, 1959 г.) Монгол Улсын архивын 1918 оны хүн амын тооны талаарх мэдээ баримттай (Б.Ширэндэвийн мэдээлснээр) зэрэгцүүлэхэд энэ тооллогын дүн 32 мянган хүнээр буюу 8 хувиар илүү гарсан нь бодит байдалд ойртсон гэж үзэж, 1918 оны тооллогыг XX зууны Монгол Улсын хүн амын анхны тооллого гэж үзсээр ирсэн ба нэгэнт түүхэнд тэмдэглэгдэн үлджээ.

Монгол орны нийгэм, эдийн засгийн хөгжил 1921 оноос өмнө нэн дорой, хүн амын эрүүлийг хамгаалах систем бүрэлдээгүй байснаас төрөлт харьцангуй өндөр, нас баралт, ялангуяа нялхсын нас баралт их байлаа. Шинэ төрсөн

хүүхдийн талаас илүү хувь нь нэг нас хүрэлгүй эндэж, амаржсан эхийн 13.2 хувь нь нас барж байсан гэсэн баримт байдаг.

Монгол улс 1918 оны тооллогоор 647.5 мянган хүн амтай байсан бол 1935 оны тооллогоор 738.2 мянга болж, 17 жилийн хугацаанд хүн амын тоо нийтдээ 90.7 мянган хүнээр, жилд дунджаар 5.3 мянгаар нэмэгдэж байжээ. Энэ хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлт 0.77 хувь байв (Зураг 1.1). Хүн амын өсөлтөд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил үүний дотор ард иргэдийн аж амьдралын түвшний өөрчлөлт, ялангуяа эрүүлийг хамгаалахын хөгжил ихээхэн нөлөөтэй нь илэрхий бөгөөд 1921 оны ардын хувьсгалын дараагаар эрүүлийг хамгаалах систем үүсч хөгжиж байсны дээр тухайн үед ЗХУ-ын (хуучин нэрээр) тусламж дэмжлэг ихээхэн ач холбогдолтой байсан нь түүхэн үнэн юм. Хүн амын нас баралтын голлох шалтгаан болж байсан цагаан бурхан зэрэг нийгмийн гоц халдварт өвчинтэй тэмцэх, энэ ажлын хүрээнд 1934-1935 онд манай улсын бүх хүн амыг хамарсан цэцгийн тариа хийж улмаар энэ өвчнийг устгасан зэрэг олон талт арга хэмжээ нь хүн амын өсөлт өмнөх үеэс нэмэгдэхэд чухал үр нөлөө болсон гэж үзэж байна. Үүний зэрэгцээгээр эмнэлгийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх эхлэл тавигдаж, 1929 онд сувилагчийн 2 жилийн курс байгуулагдаж, түүнийг 1933-1934 оны хичээлийн жилээс Хүн эмнэлгийн техникум болгон өргөтгөсөн байна. Монгол улсад 1925 онд үндэсний их эмч хоёрхон байсан бол 1935 онд 60 болж, 10 мянган хүн амд 0.1 эмч, нэг их эмчид 12.3 мянган хүн ногдож байлаа. Тухайн үед эдийн засаг, нийгмийн хөгжлөөр дэлхийд тэргүүлж байсан орнуудаас олон зуунаар хоцрогдсон Монгол орны хувьд эдгээр амжилт нь чамлахааргүй байлаа.

Гэвч хүн амын тоо 1944 онд 759.1 мянга болж, 1935 оныхоос 21.3 мянган хүнээр, жилд дунджаар 2.4 мянган хүнээр өсч байжээ. Энэ 9 жилд хүн амын жилийн дундаж өсөлт 0.32 хувь байсан нь манай улсын хүн амын тооллого хоорондын хамгийн бага өсөлт юм. Энэ хугацаанд их хэлмэгдүүлэлт, халх голын болон эх орны, чөлөөлөх дайн болсон нь хүн амын өсөлтийг өмнөх үеийнхээс сааруулж, манай улсын хүн амын өсөлтийг хамгийн бага түвшинд оруулахад нөлөөлсөн юм. Дайнд оролцсон цэрэг эрс, хэлмэгдэгсэд нь хүн амын нөхөн үржихүйд голлох нөлөөтэй идэр насныхан байсан нь тодорхой бөгөөд хэрвээ эдгээр хор уршигт үйл явдлууд болоогүй, хүн амын өсөлт ядаж өмнөх үеийнхтэйгээ адил хэмжээнд байсан бол дээрх хугацаанд хүн амын тоо 50 орчим мянгаар өсөх байсан тооцоо гарч байгаа юм.

Тус улсын хүн амын тоо 1956 онд 845.5 мянга болж, 1944 оныхоос 86.0 мянган хүнээр өссөн нь жилд дунджаар 7.8 мянган хүнээр буюу 0.98 хувиар өссөн байна. Энэ хугацаанд хүн амын өсөлтөд эерэгээр нөлөөлөх нийгэм, эдийн засгийн хүчин зүйлүүд, тухайлбал эх орны болон чөлөөлөх дайн дуусч, тус улс тайван замаар нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх нөхцөл боломж бүрэлдэж эхэлсэн үе байлаа. Манай улсад 1956 онд 354 их эмч, эмнэлгийн 6155 ор ажиллаж байсан нь 10 мянган хүн амд 4.1 эмч, 71.4 ор ноогдож байсны дээр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар өмнөх үеийнхээс давшингуй амжилтанд хүрч байсан нь хүн амын өсөлтөд сайнаар нөлөөлсөн ажээ.

Хүн амын 1963 оны тооллогоор манай улсын хүн ам 1017.1 мянга болсон нь өмнөх 1956 оны тооллогынхоос 171.6 мянган хүнээр өсч жилд дунджаар 24.5 мянгаар буюу 2.7 хувиар өссөн нь өмнөх үеийхээсээ бараг 3 дахин өндөр байна. Хүн амын өсөлт энэ үед ийнхүү нэмэгдсэн нь нийгэм, эдийн засгийн, үүний дотор ард түмний эрүүл мэндийг сайжруулах талаар төр, засгаас авч хэрэгжүүлсэн дэс дараатай арга хэмжээнүүдийн үр дүн байлаа. 1950-1960 онд хүн амыг эрүүлжүүлэх болон сүрьеэг эсэргүүцэх 2 удаагийн экспедиц ажиллуулж, тус улсын хүн амын 82.9-95.8 хувийг хамарсан үзлэг, шинжилгээ хийж, эмчлэн эдгэрүүлэх өргөн хүрээтэй арга хэмжээ авч явуулсан нь хүн амын өсөлт эрс нэмэгдэх гол хүчин зүйл болсныг тэмдэглэх нь зүйтэй. Мөн түүнчлэн 1950-1960 –аад онд аймаг дундын эмнэлгүүдийг байгуулж, эмнэлгийн тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах арга хэмжээ авсаны дүнд 1963 онд 1216 их эмч, эмнэлгийн 8995 ортой болж 10 мянган хүн амд 11.6 их эмч, 86.1 ор ногдож байв.

Хүн ам, орон сууцны 1969 оны тооллогоор 1197.6 мянган хүн тоологдсон нь 1963 оныхоос 180.5 мянган хүнээр өсч, жилд дунджаар 30 мянгаар буюу 2.8 хувиар өссөн байна. Манай улс энэ хугацаанд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх талаар олсон томоохон амжилтуудын дотор эрүүлийг хамгаалах салбарыг улам гүнзгийрүүлэн хөгжүүлж, 1961-1965 онд хөдөөгийн хөдөлмөрчдөд нарийн мэргэжлийн тусламжийг ойртуулах талаар томоохон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, сум дундын эмнэлгүүдийг олноор байгуулж эхэлсэн явдал юм. Манай улс 1969 онд 2107 их эмч, 11397 больницын ортой болсон нь 10 мянган хүн тутамд 17.1 их эмч, 92.6 ор ногдох болов.

Хүн ам, орон сууцны 1979 оны тооллогоор 1595.0 мянган хүн тоологдсон нь 1969 оныхоос 397.4 мянган хүнээр өсчээ. Энэ хугацаанд хүн ам жилд дунджаар 39.7 мянгаар буюу 2.9 хувиар өссөн нь Монгол Улсын хүн амын хөгжлийн түүхэн дэх хамгийн өндөр өсөлт байлаа. Энэ өндөр өсөлт нь эдийн засгийн өсөлтийг өмнөх үеэс эрс нэмэгдүүлж, ард түмний аж байдлыг дээшлүүлэх, үүний дотор эрүүл мэндийг нь сайжруулах талаар урт удаан хугацаанд төр, засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн байлаа. Эрүүлийг хамгаалах системийг хөгжлийн чиглэсэн зорилготой, дэс дараатай хөгжүүлэн бэхжүүлж, ялангуяа урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлж, хөдөөгийн хөдөлмөрчдөд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг улам бүр ойртуулж, эмчилгээ сувилгааны ажлын чанарыг дээшүүлэх зэрэг арга хэмжээ авсны үр дүнд 1979 он гэхэд улсын хэмжээнд 3547 их эмч, 17720 больницын төрлийн ортой болж, 10 жилийн өмнөхөөсөө их эмч 1440 -өөр, больницын төрлийн ор 5823–аар нэмэгдэж 10 мянган хүн амд 21.6 их эмч, 105 ор ногдох болжээ. Мөн түүнчлэн нийгмийн хамгаалал халамжийн олон чухал арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байсан байна.


Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогоор 2044.0 мянган хүн тоологдсон нь 1979 оныхоос 449.0 мянган хүнээр нэмэгдэж жилд дунджаар 44.9 мянгаар буюу 2.5 хувь өссөн байна. Хэдийгээр хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь өмнөх 10 жилийн дунджаас 0.4 пунктээр буурсан ч бодит өсөлтийн хэмжээ нь 5.2 мянган хүнээр илүү байгаа юм. Энэ хугацаанд эдийн засгийн өсөлт, үүний дотор үйлдвэржсэн салбаруудын өсөлтийн хурд өмнөх жилүүдийнхээс нэмэгдэж байсны гадна эрүүлийг хамгаалахын хөгжлийг улам эрчимжүүлж, улсын хэмжээнд 5715 их эмч, 24160 больницын төрлийн

ортой болж 10 мянган хүнд 29.3 их эмч, 118.2 ор ногдож байв. Энэ нь 10 жилийн өмнөхөөс их эмч 7.7 пунктээр, ор 13.2 пунктээр өссөн гэсэн үг юм.

Хүн амын өсөлт нь тухайн орны нийгэм, эдийн засгийн хөгжилтэй харилцан хамааралтай болох талаар түрүүнд товч дурьдсан. Дэлхийн олон орны хүн амын хөгжлийн практикаас үзвэл эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшилж, нийгмийн үйлдвэрлэл, үйлчилгээнд идэвхитэй оролцон, хүүхэд төрүүлж, өсгөн гэртээ суухаас татгалзах болсон үеэс тухайн орны хүн амын өсөлт саарч эхэлдэг нь нийтийн жишиг билээ. Тус улсын нийгэм, эдийн засаг 1960-аад оноос эрчимтэй хөгжиж, ялангуяа соёл, боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтүүд дэлхийн улс орнуудын дундаж, зарим талаар түүнээс ч өндөр болсон билээ. Үүний зэрэгцээгээр үйлдвэрлэл, үйлчилгээнд эмэгтэйчүүд улам өргөнөөр татагдан орж, боловсрол, эрүүлийг хамгаалах, үйчилгээний салбарт ажиллагчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байсан зэрэг нь хүн амын өсөлт, үүний дотор хүн амын төрөлт 1970-аад оны сүүлчээс аажмаар буурахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогоор тус улсын хүн ам 2373.5 мянга болсон нь 1989 оныхоос 329.5 мянган хүнээр, жилд дунджаар 30.0 мянган хүнээр буюу 1.4 хувиар өссөн байна. Энэ нь өмнөх 10 жилийн өсөлтийн дундаж хэмжээнээс 14.9 мянган хүн, 1.1 пунктээр буурсан байна. Ийнхүү хүн амын өсөлт 1980 оны дунд үеэс буурч эхэлсэн нь үүний түрүүчийн хэсэгт тэмдэглэсэн хүчин зүйлсээс гадна 1990 оны эхнээс тус улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаатай уялдаатайгаар нийгэм, эдийн засгийн хөгжилд гарсан өөрчлөлт, ард түмний аж байдлын доройтол, ажилгүйдэл газар авч байгаа, эрүүл мэндийн үйчилгээг зах зээлийн зарчмын дагуу явуулж эхэлсэн зэрэг хүчин зүйлтэй ерөнхийд нь холбон тайлбарлаж болох юм.

Зураг 1.1. Монгол улсын хүн амын тооллого хоорондын өсөлт



Монгол Улсын Их Хурлаас “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”-ыг анх удаа 1996 онд батлан гаргалаа. Уг бодлогод “Хүн амын өсөлтийн талаар баримтлах бодлогын зорилт нь 2010-2015 он хүртэлх хугацаанд хүн амын жилийн дундаж өсөлтийг 1.8 хувиас бууруулахгүй тогтвортой

хадгалах “ гэж заажээ. Хүн амын 1989-2000 оны жилийн дундаж өсөлт 1.4, хувь, 1989 оны хүн амын тооллогын үеэр Монгол улсад ажиллаж байсан ЗХУ болон социалист бусад орны мэргэжилтэн, тэдний гэр бүлийнхнийг 1989 оны дүнгээс хасч тооцвол 1.7 хувь байна. Хүн ам, орон сууцны сүүлчийн 3 тооллогын дүнгээр аймгуудыг хүн амынх нь тоогоор бүлэглэн үзүүлвэл (Хүснэгт 1.1.):

Хүснэгт 1.1. Аймгууд, хүн амын тоогоор, Хүн ам, орон сууцны сүүлчийн 3 тооллогын дүнгээр

| Он | Аймгийн тоо-бүгд | Үүнээс: хүн амынх нь тоогоор бүлэглэвэл | | | |
|----------------|------------------|---|--|--|---|
| | | 50 мянга хүртэл хүнтэй | 50-70 хүртэл мянган хүнтэй | 70-90 хүртэл мянган хүнтэй | 90 мянгаас дээш хүнтэй |
| 1979 | 20 | 7 | 6 | 7 | - |
| 1989 | 20 | 3 | 4 | 9 | 4 |
| 2000 | 21 | 2 | 5 | 8 | 6 |
| Үүнээс: нэрээр | | Өмнөговь Говьсүмбэр | Дундговь Дорноговь Сүхбаатар Булган Говь-Алтай | Хэнтий Орхон Дорнод Баянхонгор Дархан-Уул Ховд Завхан Увс | Баян-Өлгий Архангай Төв Сэлэнгэ Өвөрхангай Хөвсгөл |

Эх үүсвэр: ҮСГ, Хүн ам, орон сууцны тооллого, 1979, 1989, 2000

Хүн ам, орон сууцны 1979 оны тооллогоор 100 мянгаас дээш хүн амтай аймаг байхгүй байсан бол 1989 оны тооллогоор ганцхан Хөвсгөл аймаг 101.5 мянган хүн амтай байв. Гэтэл 2000 оны тооллогоор Өвөрхангай 111.4 мянган хүн амтай, Хөвсгөл аймаг 119.1 мянган хүн амтай болсон байна.

Аймаг, нийслэлийн хүн амын өсөлт аль ч үед харилцан адилгүй байв. Хүн амын 1979-1989 оны хоорондын өсөлт нь ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт, дотоод шилжих хөдөлгөөнөөс үндсэндээ хамаарч байсан бол 1989-2000 оны аймаг, нийслэлийн хүн амын өсөлтөд ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт, дотоод шилжих хөдөлгөөнөөс гадна гадаад шилжих хөдөлгөөний нөлөө нэлээд байсан.

Хүн амын 1979-1989 оны хоорондох жилийн дундаж өсөлт улсын хэмжээгээр 2.5 хувь байсан бол улсын дунджаас дээгүүр өсөлттэй аймаг, нийслэл 7 байсны дотор үнэмлэхүй өндөр өсөлттэй нь Орхон аймаг (13.54%), дараа нь Дархан-Уул аймаг (6.77%) байв. Хамгийн бага өсөлттэй аймаг нь Архангай (0.86%), Завхан (1.03%) байв. 1979-1989 онд хүн ам нь жилд дунджаар 2 хүртэл хувь өсч байсан аймаг, нийслэл 8 байсан бол 2-3 хүртэл хувийн өсөлттэй нь 6; 3-аас дээш хувийн өсөлттэй нь 7 байв.

Хүн амын жилийн дундаж өсөлтөөр улсын дунджаас өндөр өсөлттэй аймаг, нийслэл дөнгөж 4 байгаагийн дотор үнэмлэхүй өндөр өсөлттэй нь Улаанбаатар хот (3.5%), дараа нь Орхон аймаг (2.23%) байна. Харин энэ хугацаанд хүн амынх нь жилийн дундаж өсөлтийн хувь буурсан аймаг 5 байв. Үүнд: Дорноговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт -1.10хувь, Дорнод аймгийнх -0.66хувь, Төв аймгийнх -0.07 хувь, Хэнтий аймгийнх 0.36 хувь, Дархан-Уул аймгийнх -0.26 хувь байна.

1989-2000 оны аймаг, нийслэлийн хүн амын тооны өөрчлөлтөд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлт ч бас нөлөөлсөн тал бий, тухайлбал 1989 онд Дорноговь аймгийн бүрэлдэхүүнд байсан Чойр (Хот маягийн суурин) Говьсүмбэр аймаг болж салсан. Дархан-Уул аймгийн бүрэлдэхүүнд байсан Хөтөл хороо Сэлэнгэ аймагт шилжсэн зэргийг дурьдаж болох байна.

Дээрх гадаад, дотоод шилжих хөдөлгөөн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөс гадна бүх аймаг, нийслэлд хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт өнгөрсөн хугацаанд өмнөхөөсөө буурсаныг тэмдэглэх нь зүйтэй.

б. Хүн амын өсөлтийн ерөнхий дүр төрхөөс гарах дүгнэлт, сургамж

Аль ч улс оронд хүн амын өсөлт нь тухайн орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үе шат, ялангуяа ард түмний аж байдал, соёлын түвшинтэй нягт уялдаатай байдаг. Гэхдээ ард түмнийх нь амьдралын түвшин өндөртэй улс оронд төрөлт өндөр, хүн ам нь хурдан өсдөг гэвэл ихээхэн эндүүрэл гэдгийг өндөр хөгжилтэй орнуудын хүн амын хөгжлийн түүх бэлхэнээ харуулж байна. Харин ч бүр эсрэгээр хөгжлийн түвшин харьцангуй доогуур орнуудын хүн амын төрөлт өндөр, өсөлт хурдан байгааг бид НҮБ-аас хүн амын талаар гаргаж байгаа олон эмхтгэл, ном, хэвлэл, илтгэлүүдээс харж болох билээ.

Манай улсын хүн амын төрөлт эрс өсч, нас баралт буурч, жилийн дундаж өсөлт хамгийн оргил үедээ байсан 1950-иад оны сүүлчээс 1970 оны сүүлчийг хүртэлх хугацаа нь эдийн засаг, нийгмийн дэвшил хөгжил, ялангуяа төрөөс эрүүлийг хамгаалах, боловсролын бүх төрлийн үйлчилгээг ард иргэдэд үнэгүй үзүүлж байсан, ард түмэн нь олон хүүхэд төрүүлж өсгөх сонирхолтой хосолсон үе байлаа. Үүний зэрэгцээгээр ард иргэд хүсээгүй жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга, хэрэгслийг эзэмших мэдлэг дутмаг, хангамж, олдоц үндсэндээ байгаагүй. Хамгийн энгийн жишээ гэхэд эмийн сангуудад ч ширхэг ч бэлгэвч байхгүй, хааяа цөөн тоогоор ирдэг боловч арын хаалгаар, албан тушаалтангууд нь аваад дуусгадаг тул жирийн ард иргэд түүнийг олж, зүй зохистой хэрэглэх боломж байгаагүй гэдгийг хүн бүр мэдэх байх. Ерөндөг бол бүр нүдний гэм, ёстой л сайд, дарга нарын эхнэрүүд сайн хөөцөлдөж байж л хэрэглэдэг байсан зэрэг нь түүхэн баримт билээ. Олон хүүхэдтэй эхчүүдэд олгодог “Эхийн алдар” одон, мөнгөн урамшуулал нь олон хүүхэд төрүүлж, өсгөж байгаа гэр бүлд төрөөс үзүүлж байсан сэтгэл санаа, материаллаг урамшуулал байсан нь сайн талтай, цаашид ч улам өргөжүүлэн сайжруулах зүй ёсны арга хэмжээ мөн боловч төрөлтийг урамшуулах хүчин зүйл биш гэдэг нь амьдралаар батлагдсаар байна.

Манай улсын хүн ам, хурдан өсч байсан үед ч, өсөлтийн хурд саарч эхэлж байсан үед ч өөрөөр хэлбэл 1990 оны эх, дунд үеийг хүртэл хүн амын талаар төрөөс баримтах тодорхой бодлогогүй, тэрч бүү хэл хүн амын асуудлыг хариуцдаг яам, газар ч байхгүй байлаа.

Хүн амын тоо хурдан өсч, хүн амын насны бүтцээр залуужиж, хүүхэд, залуучуудын орон гэгдэж байсан нь нэг талаар бахархууштай сайхан

үзүүлэлт боловч нөгөө талаар хүн ам зүйн ачаалал хэт өндөр, өөрөөр хэлбэл улсын хэмжээнд авч үзвэл улсын төсвөөс нийгмийн салбарт зарцуулах хөрөнгийн эзлэх хувийн жин өндөр байна гэсэн үг юм. Айл өрхийн дотор бол ажил хийж орлого олж, амьдралаа өөд татах хүний тоо цөөн, олсон хэдийг нь тосч зарцуулдаг хүн нь олон байна гэсэн үг билээ. Хүн амын төрөлт өндөр байсныг дагалдан нялхас, эхийн эндэгдэл өндөр зэрэг сөрөг нөлөөллүүд байсныг үгүйсгэх аргагүй билээ. Зөвхөн нэг жишээ дурьдахад 1980-1989 онд амьд төрсөн 1000 хүүхэд тутмын 75-79 нь ойндоо хүрэлгүй эндэж байсан.

1970 оны сүүлчээс 1990 оныг хүртэл, ялангуяа 1980-аад оны дунд үеэс хүн амын боловсролын түвшин эрс дээшилж нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо жилээс жилд нэмэгдэхийн хирээр хүн амын төрөлт, улмаар хүн амын өсөлтийн хурд аяндаа буурч, ард иргэд, ялангуяа залуучууд, эмэгтэйчүүдийн дотор гэр бүлдээ төрүүлж, өсгөх хүүхдийнхээ тоог зохицуулах эрмэлзлэл нэмэгдэж байсан тухайн үед гэр бүл төлөвлөлтийн наад захын арга хэмжээг тэр үеийн төр, засгаас авч хэрэгжүүлэхгүй, төрөлтийг бууруулах, жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслэлийг дэлгэрүүлэхийг дэмжсэн албан тушаалтан “эсэргүү” болох нь холгүй байлаа.

Хүн ам, орон сууцны 1963, 1969, 1979, 1989 оны тооллогын хуудсанд нөхөн үржихүйн холбогдох асуултууд байсны дээр 1989 оны тооллоготой хамт төрөх насны 65 мянган эмэгтэйчүүдийн дунд нөхөн үржихүйн асуудлаар судалгаа явуулж дүнг гаргасан билээ. Сүүлчийн тооллогуудын дүн, 1989 судалгаанаас манай эмэгтэйчүүд цаашид олон хүүхэд төрүүлж өсгөх сонирхол буурч байгаа нь илт ажиглагдаж, төрөлт, хүн ам хурдан өсч байвал бүх зүйл болж байгаа мэтээр урсгалд нь ажиглаж суух боломжгүй болсон нь нэгэнт тодорхой болсон билээ.

в.Бодлогын талаарх зарим санал, дүгнэлт

Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогын дараагаар тухайн үеийн төлөвлөгөө, статистик, эрүүл мэндийн болон Шинжлэх Ухааны Академийн зарим хүрээлэн, эмэгтэйчүүдийн байгууллагууд хамтран дээрх нөхцөл байдалд бодитойгоор дүгнэлт хийж, манайд хүн амын талаар нэн даруй анхаарах 2 үндсэн асуудал байгааг төр, засгийн анхааралд хүргэх нь зүйтэй гэж шийдсэн юм. Эдгээр нь:

1/ Монгол улсын хүн амын өсөлт, нөхөн үржихүйн 1979-1989 оны бодит байдал нь эх, хүүхдийн эрүүл мэндийг цаашид тууштай сайжруулах, нас баралтыг бууруулах, гэр бүл төлөвлөлтийг өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй гэдгийг харуулж байв. Үүний үндэс нь жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх аргыг сурталчлах, түүнийг зөв хэрэглэх талаар ард иргэд, ялангуяа залуучуудын дунд зохион байгуулалтын ямар нэг арга хэмжээ авахгүй байсан нь хүсээгүй жирэмлэлт жилээс жилд асар их болж, түүнийг таслан зогсоох цорын ганц арга нь үр хөндөлт болсонтой холбоотой. Тэгэхдээ үр хөндөлтийг эмнэлэгт хийлгэхэд тусгай зөвшөөрөл шаарддаг байсан нь эмнэлгээс гадуур үр хөндүүлэх, эмч, эмнэлгийн ажилтны арга эвийг олж, (тухайн үедээ л “авилгал” өгөх) үр хөндүүлэх зэрэг ард иргэдэд чирэгдэл, эрүүл мэндэд нь хортой сөрөг

үзэгдлүүдийг хавтгайруулах шинжтэй болгосныг тухайн үеийн төр, засгийн байгууллагуудад ойлгуулсны үндсэн дээр эхний ээлжинд эмэгтэйчүүд эх болох эсэхээ өөрсдөө сайн дурын үндсэн дээр шийдэх эрхтэй болгох талаар холбогдох шийдвэр гаргасан нь анхны алхам байсан. Энд онцолж тэмдэглэхэд эмэгтэйчүүд эх болох асуудлаа өөрсдийн сайн дурын үндсэн дээр шийдэх эрхтэй болох талаарх шийдвэр гарахтай зэрэгцэн тус улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих хүндхэн зорилт тулгарч, эдийн засгийн талаар хүндрэл бэрхшээлтэй тулгарсан, социализмийн үеийн эрүүл мэндийн бүх талын үнэ төлбөргүй үйлчилгээ, зах зээлийн системээр ажиллах болсон, ажилгүйдэл, ядуурал газар авсан зэрэг хүчин зүйлтэй уялдан үр хөндүүлэх явдал эмх замбараагүй, хяналтгүй болсон нь өнөөг хүртэл үргэлжилж, анхаарах асуудлын нэг болоод байна. 1989 оны анхны тэр шийдвэр нь зарим нэг хүмүүсийн ярьж бичиж байгаачлан, монголын хүн амыг сүйрэлд хүргэх хорт муу санаатай хүмүүсийн хийсэн үйлдэл байгаагүйг нь амьдрал харуулав.

Эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд хорт үр дагавартай үр хөндөлтийг хүсээгүй жирэмслэлтийг зогсоох гол арга болгосон хэвээр байгаагийн үнэн бодит шалтгааныг олж, зохистой бодлого, арга хэмжээгээр зохицуулах цаг нэгэнт болсон байна.

Гэтэл НҮБ-ын Хүн Амын Сантай 1990-ээд оноос хойш хамтран хэрэгжүүлж байгаа олон талт үр өгөөжтэй арга хэмжээг үл ойшоож (энэ талаар хэрэгжүүлсэн арга хэмжээг тэр бүрийг дурьдах аргагүй), гагцхүү төрөлт буурч байгаатай холбон өрөөсгөл тайлбарлах, БНЭУ, Индонез, БНХАУ-д гэр бүл төлөвлөлтийн хүрээнд хэрэгжүүлдэг “Төлөвлөгөөт төрөлтийн” бодлоготой хольж хутгах, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийг сайжруулах талаар зохиож байгаа арга хэмжээг мушгин гуйвуулж байгаа зарим нэг хүмүүстэй санал нийлэх аргагүй юм.

2/ Төрөөс хүн амын талаар тодорхой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага 1990-ээд онд амьдарлаас урган гарч байсан. Үүний тулд хүн амын асуудал хариуцсан төр, засгийн төв байгууллагатай болох, орон нутагт энэ асуудлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулах нь зүйтэй байлаа.

Ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж байсан эхний үед хүн амын асуудал төр, засгийн анхаарлын төвд байж, энэ асуудлыг хариуцсан яам, аймаг, нийслэлд хүн ам, зүйн асуудал хариуцсан албан тушаалтан буй болгосон нь ихээхэн дэвшилтэй арга хэмжээ байсан. Хүн ам ба Хөгжлийн асуудлаар 1994 оны Каирын бага хурлаас дэвшүүлсэн нийтлэг зорилт, өөрийн орны хүн амын хөгжлийн онцлог байдлыг харгалзан УИХ-аас “Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”-ыг 1996 онд батлан гаргасан нь манай орны түүхэн дэх хүн амын асуудлаарх хамгийн том амжилт гэж үзэх бүрэн үндэстэй.

УИХ-ын 2000 оны сонгуулийн дараагаар байгуулагдсан Засгийн газарт хуучин хүн амын хэмээх тодотголтой байсан яамны нэрнээс “Хүн ам” гэсэн үг нь алга болсон төдийгүй уул яаманд хүн амын асуудлыг дагнан хариуцсан нэгж ч (газар, хэлтэс) үгүй болж, орон нутагт хүн амын асуудлыг өөр ажлын дайвар болгож байгаа нь олсон ололтоосоо ухарч байгаагийн нэг илрэл гэж үзэж болох юм. Тодорхой цаг хугацаанд шат шатандаа хүн

амын асуудал хариуцсан албан тушаалтны мэдлэг чадвар, ажлын хариуцлагаас хамаарч эрхэлсэн ажлынхаа талаар дорвитой ажил хийгээгүй байж болох боловч түүнийг сайжруулж засахын оронд төв, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудад хүн амынхаа асуудлыг дайвар асуудал мэт болгож байгаа нь дэлхий улс орнууд хөгжлийн төвд хүнийг тавьж байгаа нийтлэг жишиг хандлагатай болсон өнөө үед яавч зүйд нийцэхгүй болов уу.

Хүн амын асуудлаар НҮБ-ын Хүн Амын Сантай хамтран хүн амын нөхөн үржихүйн асуудлаар олон талт арга хэмжээ, үүний дотор төрөл бүрийн түүвэр судалгаа явуулж, олон төрлийн хурал, семинар, зөвлөгөөн зохион байгуулж, хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар олон санал зөвлөмж гарч байгаа ч хүн амын төрөлт буурч, үр хөндүүлэгчдийн тоо буурах нь бүү хэл нэмэгдэх хандлагатай болж, хүн амын өсөлтийн хурд саарсаар байгааг юугаар тайлбарлах вэ?.

Төрөөс хүн амын талаар баримтлах бодлогыг улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх урт, богино хугацааны зорилт, хөтөлбөртэй тухай бүр холбож, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ, материал санхүүгийн дорвитой дэмжлэг туслалцаа авагдахгүй байгаатай дээрх асуудлыг холбон үзэж болох юм. Зөвхөн ганц жишээ дурьдахад ажиллаж байгаад хүүхэд төрүүлж байгаа эхэд төрөхийн өмнө, хойно нийлээд 3 сарын хугацаанд авч байсан сарын цалин, хөдөлмөрийн хөлсийг нь 100 хувь олгож байсныг 70 хувь болгож, 4 сарынхыг олгож байгаа нь өмнөх үеийнхээсээ нэмэгдэж сайжирсан гэх үндэс байхгүй.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын эцсийн дүн гарч, тооллогын үр дүнгийн талаар чамалхааргүй олон тайлан, эмхтгэл, сэдэвчилсэн судалгаа хийгдэж, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хүртээмжтэй хэмжээгээр хэвлүүлэн, хэрэглэгчдэд хүргүүлж байгаа боловч хүн амын талаар хамгийн үнэн зөв дэлгэрэнгүй материал бүрдүүлдэг тооллогын дүнг үндэслэн хүн амын өсөлтөд нөлөөлж байгаа сөрөг үзэгдлүүдийг бууруулах талаар бодлогын яамд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд дорвитой ажил зохиож хэрэгжүүлэн, хүн амын өсөлтийн хурдыг нэмэгдүүлдэггүй юмаа гэхэд одоогийн түвшинд нь нэлээд хугацаанд хэвээр хадгалах арга хэмжээ авах талаар тодорхой ажил зохион байгуулах шаардлагатай байна.

Ном зүй

1. И.М.Маяский, 1959. Монголия накануне революций, издательство восточной литературы, Москва.
2. Монгол улсын Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого, 1996
3. ҮСГ. 1995. Монгол улсын хүн ам., УБ.
4. ҮСГ, Хүн ам, орон сууцны тооллогын үр дүн, 1979, 1989, 2000
5. “Хүн ам ба Хөгжил” Кайрын бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөр, 1994.